

ХОВД АЙМГИЙН МЭДҮҮЛГИЙГ БҮРТГЭХ, ХЯНАХ, ХАДГАЛАХ  
ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ 2015 ОНЫ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2016.02.25

Ховд аймаг

***Нэг. Мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа***

Аймгийн Авлигатай тэмцэх, шударга ёс, ил тод байдлыг хангах үйл ажиллагааны 2015 оны тайланг Авлигатай тэмцэх газраас дүгнэж 75.4 оноогоор үнэлэгдсэн.

Тайлант хугацаанд 2014 оны ХАСХОМ-ыг 271 албан тушаалтан гаргаж байсан бол 2015 оны ХАСХОМ гаргах 257 албан тушаалтаны нэрсийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлж хугацаанд нь ХАСХОМ-ийг албан тушаалтнуудаас гаргуулж цахим сүлжээнд шивж бүртгэлд хамруулав.

2015 онд шинээр албан тушаалд томилогдсон 12 албан тушаалтны урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлж хянуулан ХАСХОМ-ийг 30 хоногийн дотор гаргуулж цахим програмд шивлээ.

Мэдүүлгийн тайлан мэдээг үнэн зөв, хуулийн хугацаанд, маягтын дагуу, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хүлээн авсан тухай болон бусад бүртгэлийг бүрэн хөтөлсөн.

***Хоёр. Хяналтын үйл ажиллагаа***

Хувийн ашиг сонирхлын зөрчлийн тухай мэдэгдэл тайлбараа гаргаж хянуулаагүй 4 сумын сургуулийн захирал, 2 цэцэрлэгийн эрхлэгчид арга хэмжээ тооцож захирамжийг хүргүүлсэн. Мөн эрх бүхий албан тушаалтны үүргээ хангалтгүй биелүүлсэн сумын Тамгын газрын дарга нарт арга хэмжээ тооцож ажиллах талаар Засаг дарга нарт нь албан бичиг хүргүүлэн хариу авч ажиллав.

Эрүүл мэндийн газар, БОЭТ-ийг хариуцсан ЭБАТ болон Зэрэг, Мөнххайрхан сумын ЭБАТ-ны ажлыг шалгаж арга зүйн зөвлөгөө өгсөн.

Сумдын ЭБАТ-ны мэдүүлгийн программд шивсэн мэдээллийг өөрсдийнх нь эрхээр орж нэг бүрчлэн хянаж баталгаажуулав.

***Гурав. Зөвлөмж болон сургалт, сурталчилгааны үйл ажиллагаа***

Авлигын эсрэг болон дээд шатны байгууллагуудаас баталсан хууль тогтоомжуудыг иргэдэд танилцуулах зорилго бүхий “Авлигын эсрэг хамтдаа” самбар, авлигын эсрэг сурталчилгаа бүхий плакатыг аймгийн ЗДТГ-ын 1 давхарт байрлуулав.

Самбарт хууль тогтоомж, авлигын индекс, жилийн ажлын төлөвлөгөө, үйл ажиллагаа, мэдээ, мэдээлэл, сургалт сурталчилгаа, УИХ-ын үйл ажиллагаа, хууль зүйн зөвлөгөө, хууль, УИХ-ын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, сайдын тушаал, иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол, Засаг даргын захирамж гэсэн хэсгүүдээс бүрдэх бөгөөд мэдээллийг цаг тухай бүрт нь шинэчилж байна.



Аймгийн Засаг даргаар батлуулсан удирдамжийн дагуу 30 байгууллагын 385 албан хаагчид “Авлигын тухай ойлголт”, “Мэдэх эрх”, “Хууль дээдлэх нь”, “Давхар ажил эрхлэлтийн талаарх ойлголт” сэдвүүдээр сургалт зохион байгуулж авлигад эрсдэлтэй албан тушаалтны судалгааг авч, Засаг даргаас гаргасан авлигын эсрэг уриалгыг танилцуулан, дэмжиж гарын үсэг зуруулсан. /нотлох баримтыг хавсаргав/



Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсээс сумдын эрх зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхижуулах чиглэлээр сургалт зохион

байгуулав. Сургалтын үеэр зарим сумдын Тамгын газрын дарга нар ХАСХОМ-ийг эрх зүйн ажилтнуудаараа цахим программд шивүүлдэг бөгөөд иймд эрх зүй, дотоод ажил хариуцсан ажилтанд эрх бүхий албан тушаалтны үүргийг хариуцуулж урамшууллыг өгөх талаар санал гарсан. Сургалт зохион байгуулсан талаарх мэдээллийг [www.khovd.gov.mn](http://www.khovd.gov.mn) цахим хуудсанд байршуулсан. /нотлох баримтыг хавсаргав/

Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанаас тавьсан саналын дагуу Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар 35 албан тушаалтанд сургалт зохион байгуулсан.

2016 оны 1 сард Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан ЭБАТ-ын сургалтанд хамрагдсаны дараа буюу 2016 оны 1 дүгээр сарын 12-нд сумдын Тамгын газрын дарга нарт ХАСХОМ-ийн бүрдүүлэлтийг хугацаанд нь засвар алдаагүй бүрэн авах болон цаашид ямар ажил зохион байгуулах, ажлын сахилга хариуцлагаа өндөржүүлэх талаар сургалт зохион байгууллаа.

ХАСХОМ гаргах хуулийн хугацаа сануулах, ХАСХОМ гаргаж өгөх талаар албан тушаалтнуудтай утсаар холбогдож мессеж бичсэн. Мөн ХАСХОМ гаргах албан тушаалтнуудад мэдээлэл өгөх зорилгоор “хуулийн хугацаа сануулсан” плакатыг сурталчилгааны самбарт байршуулав.

Авлигатай тэмцэх газраас “Хуулийн хэрэгжилтийн талаар” гэсэн 2015 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 01/1589 тоот албан бичиг ирсэн бөгөөд үүний дагуу хуулийн хэрэгжилтийг хангаж хариуг 2015 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 2/584 тоот албан бичгээр, Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах тасгийн мөрдөн байцаагчаас ирүүлсэн мэдэгдлийн дагуу үйл ажиллагаа явуулж хариуг 07 дугаар сарын 21-ний өдрийн 4/1698 тоот албан бичгээр, “Холбогдох арга хэмжээ авах тухай” 07 дугаар сарын 06-ны өдрийн 01/4669 албан бичгийг хэрэгжүүлэн хариуг 07 дугаар сарын 29-ний өдрийн 1/1678 тоот албан бичгээр, “Гэрээ хянасан тухай” 08 дугаар сарын 27-ны өдрийн 01/5559 дүгээр хугацаатай албан бичгийн дагуу ажиллагаа явуулж хариуг 09 дүгээр сарын 25-ны өдрийн 1/2040 албан бичгээр тус тус хүргүүлсэн.

***Дөрөв. Бусад***

Эрх бүхий албан тушаалтны хувьд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар заалт нь нэг мөр ойлгогдох түвшинд хүрээгүй байна гэж үзэж байна.

Учир нь тус аймгийн Мөнххайрхан сумын цэцэрлэгийн эрхлэгч хамаатнаа ажилд авсан тухай иргэдээс гомдол очсоны дагуу Авлигатай тэмцэх газраас “ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсэж байна” гэж үзсэн бөгөөд мэдэгдэл тайлбараа хугацаанд нь аймгийн Засаг даргад гаргаж байна. Гэтэл тус аймгийн Дөргөн сумын сургуулийн захирал мөн хамаатнаа ажилд авсан бөгөөд энэ талаараа томилох эрх бүхий албан тушаалтан буюу аймгийн Засаг даргад зөрчлийн мэдэгдэл тайлбар гаргаагүй тухай сумын Тамгын газрын даргаас мэдээлэл авч өөрт нь энэ талаар сануулахад хуулийн үйлчлэлд хамаарахгүй учир зөрчлийн мэдэгдэл тайлбар гаргаагүй гэсэн тайлбарыг өгсөн. Ингээд манай аймаг хариуцсан мэргэжилтнээс энэ талаар тодруулахад хуулийн үйлчлэлд хамаарахгүй учир зөрчлийн мэдэгдэл гаргах шаардлагагүй гэсэн тайлбар өгсөн.

Эдгээрийг дүгнэж үзэхэд Авлигатай тэмцэх газарт гомдол, мэдээлэл очсон үед зөрчлийн мэдэгдэл тайлбар гаргах, бид өөрсдөө зөрчил илрүүлэхэд гаргахгүй байх гэсэн хуулийн зөрүүтэй ойлголт бий болсон. Үүнийг нэг мөр ойлголттой болгох шаардлагатай байна.

Мөн авлигатай тэмцэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зөвхөн аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулж хүргүүлсэн тайланг үндэслэн дүгнэдэг нь хэтэрхий өөрөөсгөл дүгнэлт гэж үзэж байна. Учир нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ажил сайн зохион байгуулдаг ч үнэлгээнд ордоггүй зөвхөн аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан ажлаар л аймаг дүгнэгддэг нь буруу. Нөгөө талаар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, тэргүүлэгч болон багийн ИНХ-ын, төлөөлөгч, тэргүүлэгчид нь тэр болгон хууль судалдаггүй улс төрждөг иргэд байдаг учраас аймгийн ИТХ-ын ажлыг хэрвээ дүгнээд эхэлбэл дээр дурдсан албан тушаалтнуудыг соён гэгээрүүлэх ажил идэвхжиж хууль хэрэгжүүлэх, хуулийн мэдлэг нэмэгдэх сайн хандлагатай. Иймд аймгийн авлигатай тэмцэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны жилийн ажлын дүнг аймгийн ИТХ, Засаг даргын Тамгын газар гэсэн 2 үнэлгээний шалгуур гаргаж нэгтгэн үнэлдэг байвал илүү шударга үнэлгээ болно. Мөн зөвхөн аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасгаас зохион байгуулсан ажлаар үнэлгээ хийх нь хуулийг иргэдэд өргөн хүрээтэй ойлгуулах мөрдүүлэхэд учир дутагдалтай байна. Аймгийн жилийн ажлын төлөвлөгөөг

байгууллага, иргэдийг оролцуулж хамруулсан ажлуудыг төлөвлүүлж тэр хэмжээгээр үнэлбэл илүү өргөн хүрээг хамарсан соён гэгээрүүлэх ажил болох байх.

Авлигатай тэмцэх газрын манай аймаг хариуцсан мэргэжилтнүүд нь эрх бүхий албан тушаалтантай нээлттэй харилцаж, арга зүйн зөвлөгөө зөвлөмж, тусламжийг хэрэгцээтэй үед түргэн шуурхай хүргэдэг. Энэ талаар ямар нэгэн санал шүүмжлэл байхгүй.

Энэ жил сумдын ЭБАТ-ны ажлыг дүгнэх үзүүлэлт боловсруулж дүгнэн ажлыг нь чанаржуулах тал дээр анхаарч ажиллахаар жилийн ажлын төлөвлөгөөндөө нэг заалт болгон тусгасан.

Цаашид сургалт сурталчилгааг байнга зохион байгуулж соён гэгээрүүлэх ажлыг тасралтгүй явуулах болно.

ТАЙЛАН БИЧСЭН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

П.ЦЭЦЭГСҮРЭН

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА

Б.БАТМӨНХ